

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Яагаад дэлхийн “бөмбөрцөг” гэж хэлдэг вэ?, намайг унтаж байхад хаана хэн хичээлдээ явж байгаа бол гэсэн асуултад хариулахын тулд эх дэлхийгээ илүү сайн судлах хэрэгтэй болно. Иймд глобус болон газрын зураг ашиглан дасгал даалгавар хийгээрэй.

Даалгавар

1 Зөв тохируулан холбоорой.

Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загвар

Дэлхийн гадаргыг хавтгайд (цаасан дээр) буулгасан зураг



2 Дэлхийн загварт хаана юу байгааг гүйцээж тэмдэглээрэй.


Нөхөх үгс: хуурай газар, ус, хойд туйл, өмнөд туйл




3 Дэлхийн газарзүйн зураг дээрх үсгүүдийг аль нь хуурай газар, аль нь далайг нэрлэсэн болохыг ялган бичээрэй.

Хуурай газар:

Далай:



4 Зураглалыг өөрийн үгээр тайлбарлаарай.



Миний бодлоор:

_____ харуулжээ.

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Яагаад дэлхийн “бөмбөрцөг” гэж хэлдэг вэ?, намайг унтаж байхад хаана хэн хичээлдээ явж байгаа бол гэсэн асуултад хариулахын тулд эх дэлхийгээ илүү сайн судлах хэрэгтэй болно. Иймд глобус болон газрын зураг ашиглан дасгал даалгавар хийгээрэй.

Даалгавар

Нөхөх үгс: газарзүйн зураг, тал бөмбөрцгийн карт, глобус


1 Тохирох үгийн нөхөж бичээрэй.

Дэлхийн хэлбэр хэмжээг багасган үзүүлсэн загварыг _____ гэнэ.


Дэлхийн гадаргыг тусгаг ашиглан хавтгайд (цаасан дээр) буулгасныг _____ гэнэ.

Дэлхийн гадаргын зөвхөн нэг тал нь бидний нүдэнд ил харагдаж нөгөө тал глобусын цаад талд байдаг тул харагдахгүй. Глобусыг хуваасан хоёр тал бөмбөрцгийг цаасан дээр буулгаж дүрсэлсэн зургийг _____ гэнэ.

2 Өгөгдсөн зүйлсийг нэрлээд, ижил ба ялгаатай талыг Эйлер-Веннийн диаграмм дээр тэмдэглээрэй.




3 Дэлхийн газрын зураг дээр хуурай газрыг -д, далайг -д нэрлэн бичээрэй. Зургаан тивийн нэрийг бичихдээ өмнө нь томоос бага руу эрэмбэлж дугаарлаарай.



Ус ба хуурай газар хэрхэн харагдахыг бичлэгээс үзээрэй.

<https://youtu.be/KDofstdo0rY>

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Манай оронд эргэх дөрвөн улирал ээлжилж байхад, Африкт үргэлж халуун байдаг. Энэ нь бид дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт амьдарч байгаагаас хамааралтай. Тэгвэл дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт амьдарч байгаагаа мэдэхэд голдож ба зэргэдийн тухай ойлголт чухал.

Даалгавар

- 1 Өгөгдсөн зурагт тохирох түлхүүр үгийг нөхөж тодорхойлолтыг гүйцээгээрэй.
Голдож, зэргэд гэж юуг хэлэх вэ?



_____ гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хойд өмнөд туйлыг холбосон, газарзүйн зураг дээр босоо татагдсан шугамыг хэлнэ.

_____ гэдэг нь дэлхийн бөмбөрцөг дээрх хөндлөн цагираг, газарзүйн зураг дээр хөндлөн татагдсан шугамыг хэлнэ.



- 2 Глобус дээрх эдгээр босоо шугамууд тэнцүү болов уу? Глобус дээрх хөндлөн цагирагууд бүгд хоорондоо ижил урттай болов уу? Хамтдаа туршиж үзээрэй.

Туршилт:

Жижиг бөмбөг эсвэл бөмбөлөг, бөөрөнхий жимс, өнгийн утас ашиглан туршилт хийж, хэмжээрэй.

- Дэлхийн бөмбөрцгийг төлүүлж буй бөөрөнхий дээр өмнөд ба хойд туйлыг тэмдэглэнэ.
- Босоо тэнхлэгийн дагуу ижил зайтайгаар хоёр туйлыг дайруулан ороож, түүнийхээ уртыг хэмжинэ.
- Босоо шугамтай харилцан эгц зэрэгцээ шугамуудыг ижил зайтай ороож уртыг хэмжээрэй.



Туршилтын үр дүн: _____




Хэрэв бөөрөнхий зүйлийг хавтгайд буулган баруун зүүн, дээд доод гэсэн тэнцүү хэсгүүдэд хуваах гол шугам бусдаас илүү урт байж чадсан эсэхийг туршиж үзэх боломжтой.

Үнэн хэрэгтээ голдож, зэргэд гэж татсан шугам байхгүй. Дэлхийн бөмбөрцөг дээр ямарваа зүйлийн байршлыг тодорхойлохын тулд зохиомлоор бий болгосон шугам юм.

- 3 Глобус дээрх хооссон нүдэнд тохирох үгийг нөхөж бичээрэй.

Нөхөх үгс: экватор, анхны голдож, голдож, зэргэд, хойд туйл, өмнөд туйл



Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг




Бид дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт амьдарч байгаа вэ? Бид далайгаас хэр хол оршдог вэ гэдгийг мэдэхийн тулд газарзүйн зургийг уншиж, байршлаа тогтоож сурах хэрэгтэй.

Даалгавар

1 Эдгээр нь дэлхийн аль хэсгийг харуулсан зураг вэ? Нэрлээрэй.


Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Энэ хагаст ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____

2 Эдгээр нь дэлхийн аль хэсгийг харуулсан зураг вэ? Нэрлээрэй.

Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____



Энэ хэсэгт ус ба хуурай газрын аль их вэ? Яагаад? _____

3 Дэлхийн хойд ба өмнөд, баруун зүүн хагасыг өнгөөр ялган будсан зураг байна.




Баруун хагас

Хойд хагас



Зүүн хагас

Өмнөд хагас



Дараах улсууд дэлхийн бөмбөрцгийн аль хагаст байгааг хүснэгтэд (√) тэмдэглээрэй.

	Баруун	Зүүн	Хойд	Өмнөд	Дэлхийн аль хагаст оршдог вэ?
Монгол					
Австрали					
Америкийн нэгдсэн улс					

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:

